# “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дугаар сарын 12-ний өдөр | дугаар 01 | Дархан –Уул аймаг

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 заалт, Дархан Нэхий Хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 заалтыг тус тус удирдлага болгон Дархан Нэхий ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-ээс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр гаргасан 2026 оны 04 дугаар сарын 12- ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 02 тоот шийдвэрийн нэг дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан Нэхий Хувьцаат компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн “ХАНГАЛТТАЙ” дүгнэлтийг баталсугай.

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ДАРХАН НЭХИЙ ХК
ТТН404 2040024

ХУРЛЫН ДАРГА Э. БАТСАЙХАН

# "ДАРХАН НЭХИЙ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дутаар сарын 12-ний өдөр    дугаар 02    Дархан –Уул аймаг

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгож, батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7, 77.1, 77.3, 77.4 заалтууд, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.23, мөн 7.10 заалтыг удирдлага болгон 2026 оын 04-р сарын 12-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Дархан Нэхий Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг доорхи бүрэлдэхүүнээр шинэчлэн сонгож, баталсугай.

Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

Эрдэнэдалай овогтой Батсайхан
Равжаа овогтой Сүмбэнхүү
Батсайхан овогтой Мягмар-Өлзий
Баасан овогтой Гэрэлмаа
Ганхуяг овогтой Ган-Очир нарыг,

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

Ринчин овогтой Бямбадорж
Баатар овогтой Бурмаа
Магван овогтой Оюунчимэг
Мягмардорж овогтой Ганзориг нарыг тус тус сонгосугай.

3. Хууль тогтоомж, компанийн дүрэм, засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний талаар олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн талаарх мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Х.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ДАРХАН НЭХИЙ
ТТД 04-ж 2043624

ХУРЛЫН ДАРГА    Э. БАТСАЙХАН

# “ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дугаар сарын 12-ний өдөр дугаар 03 Дархан –Уул аймаг

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, үйл ажиллагааны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 заалт, Дархан Нэхий Хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 заалт, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оын 04-р сарын 12-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот шийдвэрийн гурав дахь заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан Нэхий Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2026 оны цалин, урамшуулал, үйл ажиллагааны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт зардлыг хуваарийн дагуу санхүүжүүлэхийг ДНХК-ийн охин компанийн гүйцэтгэх захирд зөвшөөрсүгэй.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАРХАН НЭХИЙ ТТН4345-2045624

ХУРЛЫН ДАРГА Э. БАТСАЙХАН

Дархан нэхий ХК-ийн ХЭЗХ-ийн
2026 оны тоот тогтоолын хавсралт

## Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны зардал төсөв

| № | Сарууд | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | Нийт зардал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн зардал | 5,527,157 | 8,253,415 | 5,958,276 | 5,563,387 | 3,697,229 | 5,642,219 | 4,989,682 | 5,673,701 | 3,392,033 | 5,871,430 | 3,612,181 | 5,845,630 | 64,026,340 |
| 2 | Аудитын зардал | - | - | 3,500,000 | - | 3,500,000 | - | 3,500,000 | - | - | - | 3,500,000 | - | 11,000,000 |
| 3 | Баяр ёслолын зардал | - | - | - | 600,000 | - | - | - | - | - | - | - | 120,000 | 720,000 |
| | Гүйцэтгэл | 5,527,157 | 8,253,415 | 9,458,276 | 6,163,387 | 7,197,229 | 5,642,219 | 8,489,682 | 5,673,701 | 3,392,033 | 5,871,430 | 7,112,181 | 5,965,630 | 78,746,340 |
| | 2026 оны төсөв | 6,079,873 | 9,078,757 | 10,404,104 | 6,779,726 | 7,916,952 | 6,206,441 | 9,338,650 | 6,241,071 | 3,731,236 | 6,458,573 | 7,823,399 | 6,562,193 | **86,620,974** |
| | Хуваарилагдах зардал | **6,079,873** | **9,078,757** | **10,404,104** | **6,779,726** | **7,916,952** | **6,206,441** | **9,338,650** | **6,241,071** | **3,731,236** | **6,458,573** | **7,823,399** | **6,562,193** | **86,620,974** |
| | Компанийн нэр | **Дэвжих нэхий ББСБ ХХК** | | **Гранд як ХХК** | | **Нэхий гармент ХХК** | | **Якланд ХХК** | **Як трейд ХХК** | **Нэхий трейд ХХК** | | **Нэхий таннери ХХК** | | **100%** |

Зөвшөөрсөн:
ТУЗ-ийн дарга Э. Батсайхан

# "ДАРХАН НЭХИЙ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дугаар сарын 12-ний өдөр дугаар 04 Дархан –Уул аймаг

Тогтоолын шийдвэрийг баталгаажуулах тухай

Дархан нэхий ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оын 04-р сарын 12-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот шийдвэрийн дөрөв дахь заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 02 сарын 15-ны өдрийн 26/10 тоот тогтоолд зааснаар 2025 оны "Ногдол ашиг хуваарилах тухай" шийдвэрийг дэмжиж баталсугай.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАРХАН НЭХИЙ ХК

ХУРЛЫН ДАРГА Э. БАТСАЙХАН

**"ДАРХАН НЭХИЙ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 02 дугээр сарын 15 - ний өдөр | дугаар 26/10 | Дархан - Уул аймаг

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.8.1, 8.8.3 дахь заалтууд, тус компанийн ТУЗ-ийн 2026 оны 02 сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан нэхий ХК-ийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг нэг ж хувьцаанд 0.226 төгрөг буюу нийт 250,000,000 (хоёр зуун тавин) сая төгрөг байхаар тогтоосугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, "Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ТӨХК-аар дамжуулан 2026 оны 4 сарын 30-ны дотор багтаан олгосугай.

4. Ногдол ашиг хуваарилахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Дархан нэхий ХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Гэрэлмаа/, ерөнхий нягтлан бодогч /З. Оюунтуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Э. БАТСАЙХАН